



## “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М. ГАНБААТАР



Тоног төхөөрөмжийн  
зэсварчны аюулгүй  
ажиллагааны  
зааварчилгаа

ТТТ-ТЗ-01


Хувилбар: 1

Тушаал № А/42



# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Төвөг төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01	БАТЛАВ Гүйцэтгэх захирал /...../ М. Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 он ....сар .... өдөр
		Тушаал №	

# ТӨНӨГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага .....	4
Хоёр. Үүрэг, хариуцлага.....	4
Гурав. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага.....	5
Дөрөв. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заавар.....	5
Тав. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага .....	6

Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

### **НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА**

- 1.1. Тоног төхөөрөмжийн засварчин нь ажлын байрны тодорхойлолтын дагуу хийх ажил үүргийг гүйцэтгэх эрх, мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй байх.
- 1.2. Аюулгүй ажиллагааны үндсэн шаардлага хангаж мөрдөж ажиллах.
- 1.3. Өндөр эрсдэлтэй ажлыг нарыдаар гүйцэтгэнэ.
- 1.4. Гүйцэтгэх ажлын онцлог, ажлын байрны нөхцөлд тохирох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.
- 1.5. Засварын ажлыг хэвийн гэрэлтүүлэгтэй нөхцөлд хийнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт гэрэлтүүлэг тавьж аюулгүй байдлыг хангасан байна.

### **ХОЁР. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

- 2.1. Ажил удирдагчийн өгсөн үүрэг даалгаварыг төлөвлөсөн цаг хугацаанд технологийн горим, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж чанартай гүйцэтгэх.
- 2.2. Бие тавгүйрэх тохиолдолд ажлыг зогсоож, тоног төхөөрөмжийг унтрааж, удирдах ажилтанд мэдэгдэж, эмчид хандана.
- 2.3. Гарсан осол, зөрчил, гэмтэл, тоног төхөөрөмжийн эвдрэлийн талаар шууд удирдлага болон бусад ажилтнуудад яаралтай мэдээлэх.
- 2.4. Хориглох зүйл:
  - Ажил удирдагчийн зөвшөөрөлгүй ажлын байраа орхих, түүнд даалгаагүй ажилд оролцох;
  - Хэвийн бус ажиллагаатай багаж, туслах хэрэгслийг ашиглах;
  - Ажлын зориулалтын бус механизм ашиглах;
  - Багаж хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах;
  - Түлхүүрийг өөр түлхүүр, турба ашиглан уртасгах;
  - Түлхүүрийг алх болон бусад эд зүйлээр цохих;
  - Гаек болон түлхүүрийн хооронд төмөр болон бусад зүйл хавчуулж бэхлэх;
  - Гаек, боолтыг алх, цүүц ашиглан эргүүлэх;
  - Хэвийн бус ажиллагаатай өргөх буулгах механизм, ачаа татагчтай ажиллах;
  - Багаж хэрэгсэл, эд анги, засварын материалыг шат, цонхны тавцан зэрэг унаж болох газарт бэхэлгээ орхих, хураах;
  - Тусгай хувцасны халаасанд багаж, материал зэрэг ажлын эд зүйлс хийх, орхих, багажийг зориулалтын бусаар зөөх;
  - Зөөврийн шатнаас цахилгаан багажтай ажиллах;
  - Ажиллаж байгаа тоног төхөөрөмжид эд зүйл өлгөх;
  - Шат болон эвхдэг шатнаас үсрэх;

Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

- Тогтоосон нормоос давсан ачааг гараар зөөвөрлөх;

### **ГУРАВ. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА**

- 3.1. Ажлын байранд дараах үзлэгийг хийнэ:
  - Тоноглолыг засварт ашиглалтын зааврын дагуу зөв бэлдсэн эсэх;
  - Гэрэлтүүлэг хангалттай эсэх;
  - Шалны гадаргуу хэвийн, элдэв саадгүй, цэвэрлэсэн эсэх;
  - Үйлчилгээний талбай хэвийн эсэх;
  - Үйлдвэрийн ажлын байрны ойролцоо тоног төхөөрөмжийн цахилгаан дамжуулах хэсгийн хүчдлийг салгасан эсэх;
  - Холбогдох аюулгүйн плакат, тэмдэглэгээ байгаа эсэх;
- 3.2. Дээрх үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулж аюулгүй байдлыг бүрэн хангасан тохиолдолд ажлыг эхлүүлж болно.
- 3.3. Засварт орж байгаа тоног төхөөрөмж цахилгаан тэжээлээс салгагдсан байдал, хоолой шугам нээлттэй эсэх, цахилгаан хөдөлгүүр, эргэлдэх болон хөдлөх эд анги бүрэн унтарч зогссон эсэхийг шалгана.
- 3.4. Цахилгаан хэрэгслийн бүх засварын ажил, урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг хамгаалалтын буюу бусдын зүүсэн хувийн цоожийг цоож эзэмшигч авсны дараа хийнэ. Цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгаан гүйдлийн хэсэгт гүйдэл, ачаалал байгаа эсэхийг мэргэжлийн цахилгаанчнаар вольтметр болон ачааллын индикатораар хэмжилт хийлгэж шалгуулна.
- 3.5. Засварт орж байгаа тоног төхөөрөмж санамсаргүй цахилгаан гүйдэлд холбогдох, асах, ажиллагаатай болохоос сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг шалгаж засварын хэсгийг тусгаарлахын тулд “Асааж болохгүй-хүмүүс ажиллаж байна” гэсэн плакат байрлуулж боломжтой бол цахилгаан гүйдэлд залгагчид хувийн болон ажил удирдагч, наряд олгогч нарын хамт цоож пайзыг зүүнэ.
- 3.6. Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүрэн бүтэн хэвийн ажиллагаатай багаж хэрэгсэл, бараа материал, сэлбэгийг бэлдсэн байх.

### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

- 4.1. Хувийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн гүйцэт зөв хэрэглэнэ.
- 4.2. Ажлын горимд байгаа технологийн тоног төхөөрөмжийн хаалт, битүүмжилсэн болон бусад аюулгүй ажиллагааг хангадаг хэрэгслүүдийг хураах, ашиглахгүй байхыг хориглоно.
- 4.3. Ажлын байрыг эмх цэгцтэй, цэвэр байлгана.
- 4.4. Ширээн дээр ажиллах үед:

Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

- Шаардлагатай багаж хэрэгслийг бэлгэнэ;
- Тэдгээрийн ажиллагааг шалгаж, зөв байрлуулна;
- Ширээн дээр боловсруулж байгаа деталуудыг бэлгэнэ;
- Төмөр гадаргууг цүүцээр янзлах үед нүд хамгаалах хэрэгсэл ашиглана;
- Төмрийг гараар болон цахилгаан хутгаар хэрчихэд хэрчигчийн бүсийг сайн бэхэлнэ;
- Төмрийн зоргодсыг тусгай төмөр сойзоор цэвэрлэнэ. Үлээх, гараар арчиж авахыг хориглоно.

4.5. Цахилгаан багаж хэрэгсэлтэй ажиллах үед:

- Цахилгаан багаж хэрэгслийн гадна метал бүрхүүлийг газардуулна;
- Цахилгаан тусгаарлагч бээлий, хөл доороо цахилгаан тусгаарлагч резинэн дэвсгэр тавина;
- Цахилгаан дамжуулах шугамыг механик гэмтлээс хамгаалж, гарц, зам дээр орхихгүй байх;
- Цахилгаан хэрэгсэл хэт халсан, цахилгаан гүйдэл тасарсан болон өөрж ажлын байранд шилжүүлэх үед тэжээлийг салгана.

4.6. Преслэх, задлах:

- Дамар, муфт, холхивчийг преслэх, задлахдаа тусгай булаар гүйцэтгэнэ;
- Эд ангийг алхаар цохих, ган хөрөөгөөр хугалахыг хориглоно;
- Бул болон прессийг ашиглах боломжгүй үед зэс гадаргатай алх ашиглана;
- Механизм ба зангилааг боох задлахад гэнэт пүрш ажиллахгүй болохоос сэргийлж, хэрэгслийг хамгаалалтын хучлагаар хучиж бэхэлнэ;

4.7. Хуйхлагч дэнлүү ашиглах үед:

- Дэнлүүний хэвийн ажиллагааг шалгах, шатах бодис урсаагүй, нягтрал хэвийн эсэхийг нягтална;
- Шатах тослох материал ашиглана, этилийн спирт ашиглахгүй;
- Дэнлүүнд шатах материал хийхээс өмнө бүрэн хөргөсөн байна;
- Дэнлүүний баллонд түүний эзэлхүүний дөрөвний гурав хүртэл шатах материал дүүргэнэ;
- Шингэн асгарах, хий алдагдах зэрэг доголдол ажиглагдвал дэнлүүг унтрааж, солино;

**ТАВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА**

- 5.1. Засварлаж дууссан тоног төхөөрөмжийн эд ангиудад багаж, сэлбэг эд зүйл үлдсэн эсэхийг шалгах, тэдгээрийн зориулалтын байранд тавина.



Тоног төхөөрөмжийн зэсварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЗ-01
	Хувилбар: 1

- 5.2. Асгасан масло болон түлшийг элс, модны үртэс ашиглан арчиж, тагтай битүү хайрцагт хийнэ.
- 5.3. Ашигласан цэвэрлэгээний материалыг төмөр битүү саванд хийнэ.
- 5.4. Бүх хаалт, битүүмжлэл болон бусад хамгаалалтын хэрэгслийг байрлуулна;
- 5.5. Цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгаан хүчдэлийн залгуурт зүүсэн цоож, пайз, плакт, тэмдэглэгээг авч наряд олгогчид ажлын байрыг хүлээлгэн өгнө.
- 5.6. Засвар хийж дууссан тоног төхөөрөмжийг ажилд бэлдэх:
  - Ойр орчинд байгаа хүмүүсийг холдуулна;
  - Асаахын өмнө анхааруулах дохио өгнө;